

## Баянзүрх дүүрэг

Найрамдлын районы 1,2 хороог Найрамдлын районы 1,2 хороог 10 хороог 3 хороо, 11 хороог 4-р хороо, Амгалангийн хорооны Орон сууцны гудамжны 3-р хороог 5-р хороо, 5 хороог 6 хороо, 7 хороо 7 хороог 8 хороо, 8 хороог 9 хороо, 9 хороог 10 хороо, 4,11, 12, хороог 12 хороо, 1 хороог 13 хороо, Сүхбаатарын 9 хороог 14 хороо, 8 хороог, 15 хороо, 5 хороог 16 хороо, 7 хороог 17 хороо, 2-р хороог 18 хороо, 1 хороог 19 хороо, Хэрлэнгийн сүү фермийн Орон сууц гудамжны хороог 20 хороо болгон өөрчилсөн байна

Баянзүрх дүүрэг нь 28 хороо, 269 хэсэг Богдхан уул Бага тэнгэр, Богино Хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төрхурахын ам Хар усан тохой зэрэг газруудыг хамран оршдог.

1965 онд Баянзүрх дүүрэг 66 мянган хүн амтай орон сууц гудамжны 20 хороотой анхны захиргаа Санхүү Эдийн засгийн дээд сургуулийн байранд байрлаж байжээ.

1965 оны 06 дугаар сарын 29-ны өдөр хуралдсан Найрамдлын районы АДХГЗ-ны 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы тогтоолоор Ардын депутатуудын гүйцэтгэх захиргааны хэлтсийн дарга нарыг баталсан.

Районы хурлын үйл ажиллагаа, захиргааны эрх, аппаратын зохион байгуулалт өргөжин 179 захиргааны товчоо байгуулагдажээ. 1971 онд зохион зааварлах хэлтэс, 1976 онд Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс байгуулагдсан.

1987 онд БНМАУ-ын СнЗ-н 31 дүгээр тогтоолоор Хот тохижуулах контор болон өргөжин аж ахуйн тооцоон дээр ажиллах болжээ.

1989 оны 01 сард хүн амын тооллогоор Найрамдлын район 81,080 иргэн бүртгэгдсэн Мөн оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 45 тоот тогтоолоор Найрамдлын районы Ардын Депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд ажиллах хэлтэс тасгийн албан тушаалтнуудын жагсаалтыг баталсан.

1990 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 60 дугаар тогтоолоор Найрамдлын районы Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх зөвлөлийн орон тоог шинэчлэн тогтоож районы гүйцэтгэх захиргааны тэргүүлэгчдийн дарга нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захиргааны орлогч даргын орон тоог баталж, 1989 оны хэлтэс, тасгийн албан тушаалтны жагсаалтыг хэвээр үлдээсэн.

1990 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор Орон сууцны олон байр ашиглалтад орж өрх, хүн амын нягтрал ихэссэнийг харгалзан, Орон сууцны гудамжны 15 хороонд 1-9 байрны нийт 1080 өрх, 5160 иргэний харьяаллыг тогтоон шинээр Орон сууцны гудамжны 18 хороог байгуулан. 10-14 22 байрны 1444 өрхийн 6970 иргэнийн харьяалуулж, 15,18 хорооны хилийгн цэсийг баталсан түүхтэй.

1992 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Монгол Улсын Их хурлын 18-р тогтоолоор Найрамдлын районыг Баянзүрх дүүрэг болгон өөрчилсөн. Баянзүрх дүүрэг нь 124,4 мянган га газар нутаг засаг захиргааны нэгж болох 20 хороотой байв.

1992 оны Ардын хурлын депутатуудын 1-р сарын 4-ны өдрийн 2 дугаар тогтоолоор амьжиргааны доод түвшинд аж төрж байгаа айл өрхөд туслах "Элбэрэл санг районы сан болгон өөрчилжээ.

1992 оны 4-р сарын 28-ны өдрийн 46 тогтоолоор Боловсролын хэлтсийн дэргэд 5дугаар сарын 1-нээс Монгол бичгийн төвийг төсөвт аж ахуйн тооцоон дээр ажилуулахаар болсон.

1992 оны 04 дүгээр сарын 7-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн тасгийн татан буулгаж, Мал эмнэлгийн Үржлийн албыг 41 дүгээр тогтоолоор нутаг дэвсгэр аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс эдийн засгийг зах зээлийгн харилцаанд шилжүүлэх явцад гарч байгаа ололт амжилтыг нийтэд сурталчилах орон тооны бус Мэдээллийн алба байгуулсан.

1991оны 01 дүгээр сарын 8-ны өдөр Баянзүрх дүүргийн Засаг даргын Б/3 дугаар захирамжаар Хөдөлмөрийн биржийг, Хөдөлмөр Зохицуулалтын алба болгосон.

НИТХ-ын 1997 оны 7-р сарын 50 дугаар тогтоолоор Баянзүрх уулыг Нийслэлийн тусгай хамгаалалтад авч цогцолбор болгосон.

1997 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Б/14 захирамжаар Засаг даргын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан.

1997 оны 03 дугаар сарын 9-ны өдрийн Б/38 захирамжаар дүүргийн Тамгын газрын дэргэд Халамжийн төвийг байгуулсан. Мөн 07 дугаар сарын 29- ны өдрийн 83 дугаар тушаалыг үндэслэн Засаг даргын дэргэд Статистикийн тасгийн 4 орон тоотой байгуулсан.

1999 оны 04 дүгээр сарын 1-ны өдрийн Тамгийн газрын Нийгмийн халамж үйлчилгээний тасгийн байгуулжээ. /Тамгын газрын дүрэм, дотоод журам, хэлтсүүдийн дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулсан.

Баянзүрх дүүрэг 124,4 мянган га газар нутагтай Дүүргийн нутаг дэвсгэрт 19589 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж, Үүнээс 199 төсвийн, 2238 төрийн бус байгууллага байна. Мөн төрийн Өмчит Үйлдвэрийн газар 23 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 12 шашны 67 байгууллага дүүргийн нутаг дэвсгэр үйл ажиллагаагаа явуулж байна.